



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

## ГААЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР

14193 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,  
Их тойруу 81/1, Утас/Факс: (976-11) 35 00 60,  
И-мэйл: info@customs.gov.mn, Вэбсайт: www.customs.gov.mn

2022. 08. 01 № 01/2056

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Төсвийн төсөл хүргүүлэх тухай

Гаалийн байгууллага нь ирэх онд “Шинэ сэргэлтийн бодлого” болон “Гаалийн шинэчлэл”-ийн төсөл хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг хангаж, хилийн боомтын нэвтрүүлэх, хяналт тавих хүчин чадлыг сайжруулах, гадаад худалдааны бараа бүтээгдэхүүнд хийх гаалийн хяналт шалгалтыг сайжруулах, татварыг ногдуулах, гаалийн бүрдүүлэлтийн үйл ажиллагааг түргэн шуурхай, чирэгдэл багатай болгох, гаалийн харилцаанд оролцогчдод үзүүлэх үйлчилгээний чанарыг дээшлүүлэн олон улсын хууль ёсны худалдааг хөнгөвчлөх, байгууллагын дэд бүтэц, чадавхийг бэхжүүлэх, улсын төсвийн орлогыг бүрдүүлэн ажиллахаар зорилт тавьж Сангийн сайдын 2019 оны 282 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах” журмын дагуу 2023 оны урсгал болон хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төсвийн төслийн саналыг боловсрууллаа.

Мөн Засгийн газрын “Агаарын замын Чингис хаан хилийн боомтын талаар авах арга хэмжээний тухай” тогтоолын хэрэгжилтийг хангах, “Шинэ сэргэлтийн бодлого” хөтөлбөрийн 1 дүгээрт тусгагдсан “Боомтын сэргэлт” багц асуудлын хүрээнд 2023 онд зайлшгүй хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг онцлон төлөвлөж, урсгал төсвийг тооцон тусгалаа Үүнд:

1. Монгол улсын Засгийн газрын 2022 оны 228 дугаар тогтоолын 3.2-т заасан Агаарын замын “Чингис хаан” хилийн боомтод суурилуулах зорчигчийн гар тээш шалгах рентген төхөөрөмж худалдан авах зардал;
2. Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр бүтээн байгуулалт хийгдэж буй Алтанбулаг, Боршоо, Гашуунсухайт боомтуудад зорчигчийн гар тээш шалгах рентген төхөөрөмж болон хүний биед үзлэг шалгалт хийх рентген төхөөрөмжүүд худалдан авах зардал;
3. Мөн бүтээн байгуулалт хийгдэж буй зарим боомтуудын шалган нэвтрүүлэх цогцолборын тохижилт, тоног төхөөрөмж худалдан авах зардал;
4. Зарим хилийн боомтуудын хэвийн үйл ажиллагааг хангах зайлшгүй шаардлагатай барилга байгууламжийн их засварын зардал;
5. Гаалийн шинэчлэлийн хүрээнд 2019 оноос хэрэгжүүлж буй гаалийн хяналт шалгалтын тоног төхөөрөмжүүдийн 2023 онд нийлүүлэгдэх тоног төхөөрөмжүүдийн төлбөр;
6. БНХАУ-ын Засгийн газрын буцалтгүй тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй Замын-Үүд, Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжүүлж буй Алтанбулаг, Сүхбаатар, Боршоо боомтуудын барилга байгууламжууд 2022 онд ашиглалтад орж байгаатай холбоотойгоор урсгал болон байр ашиглалтын зардал;
7. Хөшигийн хөндий дэх Хил хяналтын байгууллагуудын Нэг цэгийн үйлчилгээний барилга, байгууламжийн урсгал болон байр ашиглалтын зардал;

1439507 2558

8. Гаалийн мэдээллийн нэгдсэн системийн шинэчлэлийн хүрээнд Азийн хөгжлийн банкнаас санхүүжүүлэн худалдан авсан тоног төхөөрөмж, програм хангамж болон байгууллагын дотоод үйл ажиллагааны програм хангамжуудын албан ёсны ашиглалтын эрх бүхий лицензийн төлбөр;


9. Гаалийн шинэчлэлийн хүрээнд нийлүүлэгдэж буй бараа тээврийн хэрэгслийн хяналтын рентген аппарат болон нүүрснээс дээж авагч рентген флюоресцент төхөөрөмжүүдийн гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвар;

10. Гаалийн лабораторийг олон улсын итгэмжлэлд хамруулах олон улсын зөвлөх үйлчилгээний багтай 2020 онд гэрээ байгуулан ажиллаж байгаа бөгөөд коронавирусын цар тахлын нөхцөл байдлаас шалтгаалан гаалийн төв болон салбар лабораторийн барилгууд хугацаа хоцорч ашиглалтад орсон, мөн тоног төхөөрөмжүүдийн нийлүүлэлтийн хугацаа хойшлогдсон зэргээс шалтгаалан олон улсын зөвлөх үйлчилгээний багын төлөвлөсөн ажил хойшлогдож, гэрээний хугацааг 2024 оны 06 дугаар сар хүртэл сунгасан тул нэмэлт санхүүжилт зэргийг тус тус тооцсон.

Иймд нийт 119,4 тэрбум төгрөгийн урсгал төсөв, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхэд 60,6 тэрбум төгрөг шаардлагатай байгаа тул дээрх манай төсвийн төслийн саналыг судлан үзэж, шийдвэрлэж өгнө үү.

Хавсралт ~~1~~ хуудастай.

ДАРГА



Б.АСРАЛТ



Гаалийн байгууллагын 2023 оны төсвийн төсөл, 2024-2025 оны төсвийн төсөөлөл

Код	1. Гүйцэтгэл		2. 2022 ХБГ		3. Санал		4. 2023 ТЭЗ санал		5. 2024 төсөөлөл		6. 2025 төсөөлөл		7. 2021 гүйц 2022 ХБГ		8. 2022 бнт 2023 хяз 2023 снз		9. Өөрчлөлт		
	Гүйцэтгэл		ХБГ		ТЭЗ санал		ТЭЗ санал		төсөөлөл		төсөөлөл		2021 гүйц 2022 ХБГ		2022 бнт 2023 хяз 2023 снз		Өөрчлөлт		
	2021 Гүйцэтгэл	2022 ХБГ	2023 ТЭЗ санал	2023 ТЭЗ санал	2024 төсөөлөл	2025 төсөөлөл	2021 гүйц 2022 ХБГ	2022 бнт 2023 хяз 2023 снз	2022 бнт 2023 хяз 2023 снз	2023 хяз 2023 снз	2023 хяз 2023 снз	2023 хяз 2023 снз	2023 хяз 2023 снз	2023 хяз 2023 снз	2023 хяз 2023 снз	2023 хяз 2023 снз	2023 хяз 2023 снз	2023 хяз 2023 снз	2023 хяз 2023 снз
<b>А. Зардлын эдийн засгийн зүйлс</b>																			
2101	Цалин хөлс болон урамшил	25,937,609.3	43,003,675.3	61,863,601.8	80,422,682.4	104,549,487.1	60.3	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх	3,427,004.3	5,241,748.3	8,970,222.3	11,661,288.9	15,159,675.6	65.4	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,678,165.0	3,818,602.5	8,078,620.3	10,502,206.4	13,652,868.3	43.9	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
2104	Хангамж, бараа материалын зардал	922,797.1	878,930.8	2,548,717.5	3,313,332.7	4,307,332.5	105.0	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
2105	Нормативт зардал	491,817.7	3,505,973.3	4,710,767.7	6,123,997.9	7,961,197.3	14.0	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
2106	Эд хогшил, урсгал зардал	2,712,224.1	4,431,212.4	7,968,434.2	10,358,964.5	13,466,653.8	61.2	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
2107	Томилголт, зочны зардал	135,988.5	177,546.0	627,742.5	816,065.3	1,060,884.8	86.3	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн АУТХ	3,264,129.9	4,897,908.5	12,462,678.7	16,201,482.3	21,061,927.0	66.6	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	198,112.4	1,182,221.2	5,844,083.8	7,597,308.9	9,876,501.6	16.8	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
212	Тагаас																		
213	Урсгал шилжүүлэг	1,070,896.9	1,820,283.9	6,380,719.3	8,294,935.1	10,783,415.6	58.8	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
22	Хөрөнгийн зардал																		
##	Бусад																		
<b>НИЙТ, Зардлын зүйл*</b>		<b>MNT 39,838,745.2</b>	<b>MNT 68,958,102.2</b>	<b>MNT 119,455,588.0</b>	<b>MNT 155,292,264.4</b>	<b>MNT 201,879,943.7</b>													

Б. Зардлын зориулалт-арга хэмжээ

80100	Үндсэн үйл ажиллагаа	35,305,606.0	61,057,688.6	94,768,106.2	123,198,538.1	160,158,099.5
80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	35,305,606.0	61,057,688.6	94,768,106.2	123,198,538.1	160,158,099.5

**НИЙТ, Зардлын зориулалт-арга хэмжээ \***

MNT 35,305,606.0	MNT 61,057,688.6	MNT 94,768,106.2	MNT 123,198,538.1	MNT 160,158,099.5
------------------	------------------	------------------	-------------------	-------------------

В. Санхүүжүүлэх эх үүсвэр


31	Улсын төсөв	38,611,598.0	67,750,955.0	118,228,440.8	154,065,117.2	200,652,796.5	57.0
310003	ЗГ-ын тусгай сан						
310002	Тусгай зориулалтын шилжүүлэг						
32	Орон нутгийн төсөв						
33	Нийгмийн даатгалын сан						
35	Үйл ажиллагааны орлого	1,227,147.2	1,227,147.2	1,227,147.2	1,227,147.2	1,227,147.2	100
36	Тусламж						
37	Бусад эх үүсвэр						

**НИЙТ, Эх үүсвэр**

MNT 39,838,745.2	MNT 68,958,102.2	MNT 119,455,588.0	MNT 155,292,264.4	MNT 201,879,943.7
------------------	------------------	-------------------	-------------------	-------------------

Г. Хөтөлбөрийн орон тооны мэдээлэл

1. Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)																				
2. Төрийн тусгай албан хаагч (ТТ)	1,245.0	#	1,805.0	#	1,805.0	#	1,805.0	#	1,805.0	#	1,805.0	#	1,805.0	#	1,805.0	#	1,805.0	#	1,805.0	#
3. Ажлын албаны албан хаагч (АА)																				





- 4.СӨБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)
- 5.ШУ-ны салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮШУ)
- 6.Соёл урлагийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮСУ)
- 7.Мэргэжлийн боловсролын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮМБ)
- 8.Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ)
- 9.Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)
10. Гэрээт ажилтан

Нийт, Орон тоо	MNT 1,603.0	MNT 2,326.0	MNT 2,326.0	MNT 2,326.0	MNT 128.3	MNT 285.2	MNT 140.2
----------------	-------------	-------------	-------------	-------------	-----------	-----------	-----------

<b>Е.Хөтөлбөрийн шалгуур үзүүлэлт</b>							
xx Гүйцэтгэлийн үр дүн (1)	MNT 35,305,606.0	MNT 61,057,688.6	MNT 94,768,106.2	MNT 123,198,538.1	MNT 160,158,099.5	86.4	99.4
xx Гүйцэтгэлийн үр дүн (2)	4,533,139.2 MNT	7,900,413.6 MNT	24,687,481.8 MNT	32,093,726.3 MNT	41,721,844.2 MNT	96.1	99.9
	309.0	521.0	521.0	521.0	521.0		59.3
	49.0						

### ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР:

\*Сонхүүжилтийн эх үүсвэр, хөтөлбөрийн зардал, зардлын зориулалт болон арса хэмжээ болон байгууллагаар хуваарилсан дүн хоорондоо тэнцрж байх ёстой.

Е. Хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх 2021-2024 онуудын гол зорилтууд

- ЗОРИЛТ 1: Олон улсын хууль ёсны худалдааг хөнгөвчлөх, түүний аюулгүй байдлыг хамгаалах,  
 ЗОРИЛТ 2: Улсын хилээр хууль бусаар бараа, тээврийн хэрэгслийг нэвтрүүлэхтэй тэмцэх,  
 ЗОРИЛТ 3: Улсын төсвийн орлогыг шударга, үр ашигтай, үр дүнтэй бүрдүүлэх,  
 ЗОРИЛТ 4: Гаалийн байгууллагын лэд бүтэц, чадавхыг бэхжүүлэх.

3. Төсвийн хязгаараас лавсан саналын үйлдвэрлэл, тайлбар, нотолгоо: МУ-ын Засгийн газрын тогтоолын хэрэгжилтийг хангах, Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолоор Коронавируст халдвар /Ковид-19/-г цар тахлын өдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, хөгжлийг хязгаарлагч хүчин зүйлийг цаг алдалгүй шийдвэрлэх зорилготой "Шинэ сэргэлтийн бодлого"-ийг хэрэгжүүлэх зорилгоор гаалийн шинэчлэлийн ажлыг эрчимжүүлж, боомтын бүтээн байгуулалтын ажлыг түргэвчлүүлэн, тоног төхөөрөмжийн угсралтыг зэрэгцүүлж хийхээр үе шаттай зохион байгуулагдаж буй төсөл хөтөлбөрүүдтэй уялдуулан Гаалийн байгууллагын 2023 оны урсгал зардлыг тооцон төлөвлөв. Үүнд:

**Цалин хөлс болон нэмэгдэл урамшил НДШ:** Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлд заасны дагуу нийт албан хаагчдын цалин хөлсийг тооцож төсөвлөсөн. мөн Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын дагуу төрийн албан хаагчдад улирлын ажлын үр дүнтэй олох мөнгөн урамшуулалыг нэмж олгох, Монгол улсын засгийн газрын 198 дугаар тогтоолоор "Хятад, Монголын хилийн боомт, тэдгээрийн дэглэмийн тухай БНХАУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээр"-ээр Дорнод аймаг дахь гаалийн газрын Баянхоншууны хилийн боомтод ажиллаж байгаа албан хаагчдын Бямба, Нам гараг болон нийтээр тэмдэглэх баярын өдөр ажиллуулахад гарах цалин хөлсийн зардлыг Засгийн газраас шийдвэрлэж байхаар тусгасан. Мөн Ковид-19 цар тахлын нөлөөтэй холбоотойгоор Гашуунсухайт, Шивээхүрэн, Алтанбулаг, Замын-Үүд, Ханги зэрэг боомтууд болон зарим гүний гаалийн байгууллагуудын ажиллах цагийг нэмэгдүүлснээр албан хаагчид илүү цаг олгохоор нэмж төсөвлөсөн.

**Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал:** Хөшигийн хөндий дэх Нэг цогийн үйлчилгээний барилга, байгууламжууд болон төсөл хөтөлбөрөөр хэрэгжүүлж буй Замын-Үүд, Алтанбулаг, Бичигт, Боршоо боомтуудын бүтээн байгуулалтууд 2022 онд ашиглалтад орж байгаагаар холбоотойгоор байр ашиглалтын зардал болон бусад холбогдох урсгал зардлыг нэмэгдүүлж төсөвлөсөн.

**Хангамж, бараа материалын зардал:** Байгууллагын өлөр тугмын хэвийн үйл ажиллагааг ханган явуулахад шаардагдах хангамж, бараа материалын хэрэгцээ шаардлага, зах зээлийн үнийн судалгаанд үндэслэн уг зардлыг нэмэгдүүлэн төсөвлөсөн.

**Нормативт зардал:** Эм бэлдмэл ангилад: Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 04 дүгээр тогтоолоор Мэргэжлийн хяналтын байгууллагын улсын хилээр нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгсэлд хорно цээр, эрүүл ахуй, чанарын тохирлын хяналт шалгалт хийх чиг үүрэг Гаалийн байгууллагад шилжин ирсэнгүй холбоотой ариутгал халдваргүйжүүлэлтийн бодис худалдан авах зардал, гаалийн болон хорно цээрийн лабораториудад шаардлагатай материалын зардлыг мөн гаалийн албаны эрэлч ноход шилдэг 1 удаа галуугын вакцин мөн олон цэнгэт вакцинд хамруулах улирал тутамд гадна болон дотор паразитын эсрэг эм бэлдмэл мөн шаардлагатай хэрэглэх эм бэлдмэлээр хангах, нохойн хоолны сав гална талбай үүр ариутгах, ариутгал халдваргүйжүүлэлтийн бэлдмэл худалдан авах зардлыг тус тус төсөвлөсөн. Хоол хүнс ангилад албаны 50 гаруй эрэлч нохойн зориулалтын хоолны зардлыг төсөвлөсөн. Эрэлч нохойн өдрийн хоолны норм нь том нохойнд 1 улаадаа 750 гр ба жижиг нохойнд 500 грамаар бодогдож олгодог. Уг тогтоосон норм нь нохойн өдөр тутмын хэрэгцээг хангахад дутагдалтай байдаг учраас 2 дахин нэмэгдүүлж, мөн үйлдвэрийн хоолнууд нь өвлийн улиралд нохойн дулааныг хадгалахад муу байдаг ба нэмэлтээр мах махан бүтээгдэхүүнүүдийг авч хэрэглэх шаардлагатай байна гэдэг саналыг эрэлч нохойн албанаас ирүүлж 1 жилд өвлийн улиралд 50кг түүхийн мах, 700 ширхэг малын өвчүү, 700 ширхэг дотор гэдсийг цуглуулан авч эрэлч ноходоо хооллодог. Нэг кг нохойн зориулалтын хоолны зах зээлийн дундаж үнэ 8000 төгрөг байна. Тиймээс эрэлч нохойн хоолны норм нормативыг зайлшгүй нэмэгдүүлж шаардлагатай байна. Мөн хоол хүнс ангилад лабораторийн албан хаагчид болон ариутгалч нарын хор саармагжуулах бүтээгдэхүүний зардлыг төсөвлөсөн. Нормын хувцас зөөлөн элдэл ангилад нийт 1805 төрийн тусгай албан хаагчийн дүрэмт хувцасны хангалтад 2,6 тэрбум төгрөг төсөвлөсөн. Албан хаагчдын дүрэмт хувцасны хангалтад материал ирүүлээгүй шалтгаануудаар нундагдсан тул 2023 онд 4-5 хөрш хийгдээгүй, 2019-2022 онуудад зохион байгуулсан худалдан авалтын төсөвлөсөн.



**Эд хогшил, урсгал засварын зардал:** Байгууллагын үндсэн үйл ажиллагааны зориулалтаар ашиглахад хуульчилсан ажиллагааны зардал болон албан хэрэгтэй ашиглагдах компьютер, принтер, сканнер зэрэг тоног төхөөрөмжийг өвөн тоогоор худалдан авах зардал, урсгал засварын зардал "Шинэ сэргэлтийн боллого" хөтөлбөрийн I дүгээрт тусгагдсан "Боомтын сэргэлт" багц асуудлын I.1.5-д "Боомтуудын үндсэн байгууламж /эрчим хүч, дулаан, усан хангамж, ариутгах татуурга, интернэтийн сүлжээ, гаалийн лаборатори, зорчигч болон ачаа тээврийн терминал/-ийг өргөтгөн шинэчилж, зорчигч аялах, албан хаагчдын ажиллах ая тухтай орчныг бүрдүүлэх" гэж тусгагдсан дагуу хилийн боомтуудын хэвийн үйл ажиллагааг хангах, гаалийн хяналт шалгалтын тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээг хангахтай холбогдсон зардлууд багтсан.

**Хөдөлмөр хамгаалал:** Гаалийн төв лаборатори болон салбар лабораториудын албан хаагчид болон хорнон цээрийн албаны ариутгагч, эрэлч нохойн албаны сургагч нарын хөдөлмөр хамгаалалын хувцас хэрэгсэл худалдан авах зардал мөн дэлхий нийтэд тархаад байгаа цар тахал болон халдварт өвчний эсрэг харну арга хэмжээнүүдийг авахад шаарглагдах зардлыг тооцож төсөвлөсөн. Жнь. Халдварын голомтот бүсэд үүрэг гүйцэтгэж байгаа албан хаагчдад халдварын эрсдлээ хамгаалах, урьдчилан хамгаалалтын хувцас хэрэгсэл, ариутгалын болдс г.м

**Томилголт, зочны зардал:** Гаалийн байгууллага нь харьяа гаалийн газар хороодод хяналт шалгалт хийх, дотоод аудит болон бусад боомтын үйл ажиллагааг идэвхижүүлэх зорилгоор харьяа 18 газар, хороонд албан томилолтоор ажилладаг тул томилолтын зардлыг Сангийн сайдын 2022 оны 12 дугаар тушаалаар батлагдсан тарифаар, шатахууны зарлагыг зах зээлийн ханшаар тооцон төсөвлөсөн. Мөн гаалийн шинэчлэлийн хүрээнд харьяа боомтууд дээр хийгдэж буй хөрөнгө оруулалтын ажлууд, төсөл хөтөлбөрүүдийн бүтээн байгуулалтын ажлын явцтай тухайн боомт дээр очиж танилцах, хяналт тавих зайлшгүй шаардлага үүсч байгаа тул тус зардлыг нэмэгдүүлж төсөвлөсөн.

#### **Бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний төлбөр хураамж:**

1. Гаалийн мэдээллийн нэгдсэн системийн шинэчлэлийн хүрээнд Азийн хөгжлийн банкнаас санхүүжүүлэн худалдан авсан тоног төхөөрөмж, програм хангамж болон байгууллагын дотоод үйл ажиллагааны програм хангамжуудын албан ёсны ашиглалтын эрх бүхий лицензийн төлбөр.
2. Гаалийн лабораторийг олон улсын итгэмжлэлд хамруулах олон улсын зөвлөх үйлчилгээний багтай 2020 онд гэрээ байгуулан ажиллаж байгаа бөгөөд коронавирсын цар тахлын нөхцөл байдлаас шалтгаалан гаалийн төв болон салбар лабораторийн барилгууд хугацаа хоорч ашиглалтад орсон, мөн тоног төхөөрөмжүүдийн нийлүүлэлтийн хугацаа хойшлогдсон зэргээ шалтгаалан олон улсын зөвлөх үйлчилгээний багтын төлөвлөсөн ажил хойшлогдож, гэрээний хугацааг 2024 оны 06 дугаар сар хүртэл сунгасан тул нэмэлт санхүүжилт.
3. Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 04 дүгээр тогтоолоор Мэргэжлийн хяналтын байгууллагын улсын хилээр нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгсэлд хорио цээр, эрүүл ахуй, чанарын тохирлын хяналт шалгалт хийх чиг үүрэг Гаалийн байгууллагад шилжин ирсэнтэй холбоотой хорио цээрийн хяналт, шалгалтад ашиглагддаг 27 ширхэг маягтын хэвлүүлэх зардал, болон дэлхий нийтэд тархаад байгаа цар тахал, халдварт өвчтэй холбоотой Олон улсад шуурхай мэдээлэх хүний хөл хорног өвчнөөс урьдчилан сэргийлэх, харну арга хэмжээ авах улсын хилээр нэвтрэх буй зорчигчдоор бөглүүлэх "Эрүүл мэндийн мэдүүлгийн хуудас" хэвлүүлэх зардлыг тооцож төсөвлөсөн. Мөн гаалийн хяналт шалгалтын зорилгоор ашиглагддаг "Зорчигчийн гаалийн мэдүүлгийн маягт", хатуу дугаар бүхий нэг улаагийн троссон ломбоны худалдан авалт 2020 оноос хойш хийгдээгүй бөгөөд 2023 онд худалдан авалтыг зайлшгүй зохион байгуулах шаардлагатай байгаа тул уг зардлыг тооцож төсөвлөсөн.

**Бараа үйлчилгээний бусад зардал:** Гаалийн шинэчлэлийн хүрээнд нийлүүлэгдэж буй бараа тээврийн хэрэгсэлийн хяналтын рентген аппарат болон нүүрснээс дээж авагч рентген флюоресцент төхөөрөмжүүдийн гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвар, болон Гамшгаас хамгаалах тухай хуулийн 51.2-д заасны дагуу тухайн жилийн төсвийн 1%-ийг төлөвлөж зарцуулна гэсэн заалтын дагуу зардлыг тусгасан. Гаалийн байгууллага нь Дэлхийн гаалийн байгууллагын гишүүн орон тул уулзалт хурал зөвлөгөөн болон зочин төлөөлөгчийг хүлээн авах зайлшгүй шаардлага гардаг тул гаалад арга хэмжээтэй холбоотой зардлыг нэмж төсөвлөсөн. Гаалад албан томилолт болон зочин төлөөлөгч хүлээн авах зардлын төсвийг Сангийн яамнаас олгохгүй байгаа.

**Дээж худалдан авах:** Гаалийн болон цээрийн лабораториудын үйл ажиллагаанд шаардлагатай стандарт дээж, урвалж болсн, зориулалтын шил савны зардлыг тооцож төсөвлөсөн.

**Засгийн газрын гадаад шилжүүлэг:** Гаалийн байгууллага нь Дэлхийн гаалийн байгууллагын гишүүн орон тул жил бүр гишүүнчлэлийн татвар 27,000 евро төлдөг. Уг зардал валютын ханшны өсөлтөөс шалтгаалж өссөн болно.

ГААЛИЙН БАЙГУУЛЛАГЫН 2023 ОНЫ УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРГУУЛАЛТААР ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВӨЛТ

№	Аймаг, Нийслэл	Сум, Дүүрэг	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Хэмжих нэгж	Хүчин чадал	Объектын төрөл	Объектын ангилал	Хуучин				Нийт авсан санхүүжилт лт /сая төгр/	Байгууллагын санал		Он даамжир хэрэгжих бол дараагийн жилийн	Төсвийн өрөнхийлөн захирагч	
								Эзлэх	Дуусах	2019	2020		2021	2022			Төсвийн төсөлд тусгах төсөвт өртөг /сая төгрөг/
			<b>I.Барилга байгууламж</b>														
			ШИНЭ														
1	Баян-Өлгий	Баян-Өлгий аймаг дахь гаалийн газар	Албан котгорын барилга шинээр барих	м2	1085.6	Котгорын барилга	Барилга байгууламж	2023						1230.0	1230.0		Сайгийн нам
2	Дорноговь	Заман-Уул боомт	Ажилчдын орон сууцны барилга /ГЗ айл/	м2	1654.7	Орон сууцны барилга	Барилга байгууламж	2023									Сайгийн нам
3	Дорноговь	Сайнацад дахь гаалийн газар	Ажилчдын орон сууцны барилга /ГЗ айл/	м2	1654.7	Орон сууцны барилга	Барилга байгууламж	2023									Сайгийн нам
1	Увс	Увс аймаг дахь гаалийн газар	Гаалийн хяналт бүрдүүлэлтийн барилга	м2	1272.4м зөөрөгтэй 2 давхар	Котгорын барилга	Барилга байгууламж	2022	1900.0					1230.0	1230.0		Сайгийн нам
			<b>II.Их засвар</b>														
			ШИНЭ														
1	Дорноговь	Заман-Уул боомт	Гаалийн ажилчдын орон сууцны их засвар	м	1959	Орон сууц	Их засвар	2023						3171.6	3171.6		Сайгийн нам
2	Дархан-Уул	Дархан-Уул аймаг дахь гаалийн газар	Котгорын барилгын их засвар	м2	1072	Орон сууц	Их засвар	2023						900.0	900.0		Сайгийн нам
3	Улаанбаатар	Улаанбаатар хот дахь гаалийн газар	Котгорын барилгын лифтийн их засвар	ш	2	Орон сууц	Их засвар	2023						450.0	450.0		Сайгийн нам
4	Сэлэнгэ	Увс аймаг дахь гаалийн газар	Гаалийн ажилчдын орон сууцны их засвар	айл	77	Орон сууц	Их засвар	2023						935.0	935.0		Сайгийн нам
5	Улаанбаатар	Гаалийн өрөнхий газар	Гаалийн өрөнхий газрын сургалт, судалгааны төвийн их засвар	м2	650м2, 12 өвөр	Сургалтын өрөө	Их засвар	2023						228.6	228.6		Сайгийн нам
			<b>III.Тонот төхөөрөмж</b>														
			ШИНЭ														
1	Улаанбаатар	Гаалийн өрөнхий газар	Гаалийн шинэчлэлт-Гаалийн өрөнхий газар, газар, хороодын лабораторийн тоног төхөөрөмж /Улсын хэмжээнд/	Их бүрдэл	5	Лабораторийн тоног төхөөрөмж	Тонот төхөөрөмж	2019	6,119.20	500.00	9,953.00	14,300.00	500.00	57,500.00	12,230.00		Сайгийн нам
2	Улаанбаатар	Гаалийн өрөнхий газар	Гаалийн шинэчлэлт-Гаалийн өрөнхий газар, газар, хороодын шуурхай удирдлагын төв, хяналт шалгалтын тоног төхөөрөмж, дэд бүтцийн хяналт Улсын хэмжээнд/	Их бүрдэл		Хяналт шалгалтын тоног төхөөрөмж	Тонот төхөөрөмж	2019	464.00	500.00	15,946.70	26,915.20	500.00	114,143.90	36,300.00		Сайгийн нам
3	Улаанбаатар	Гаалийн өрөнхий газар	Гар тээш шалгах рентген төхөөрөмж хүний биед утгагч их рентген төхөөрөмж Чингис Хаан олон улсын нисэх буудал дахь гаалийн газар, Сэлэнгэ аймаг дахь гаалийн газар Алтанбулаг боомт, Боршио, Өмнөговь аймаг Гашуунсухайт боомт, Увс хороодын шуудан илтгэмжийн гаалийн газар/	ш	12	Хяналт шалгалтын тоног төхөөрөмж	Тонот төхөөрөмж	2023						3,100.00	3,100.00		Сайгийн нам
4	Улаанбаатар	Гаалийн өрөнхий газар	Боомт сургалтын хүрээнд зарим жилийн боомтын цэцэрлэгийн тохиолтын тоног төхөөрөмж /Гашуунсухайт болон салбар лабораторийн тоног төхөөрөмж			Тавилга, буцад тоног төхөөрөмж	Тонот төхөөрөмж	2023						2,620.00	2,620.00		
			<b>НИЙТ ДҮН</b>											<b>181,765.50</b>	<b>60,651.60</b>		